



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

“ Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа ”
эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахыг
зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 407 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам”-ын 5.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ард даатгал” ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 1,500,000,000.00 /нэг тэрбум таван зуун сая/ төгрөгөөр нэмэгдүүлж, хавсралтад заасны дагуу хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Ард даатгал” ХК /Г.Цогбадрах/-д үүрэг болгосугай.

3. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх талаар хууль тогтоомжид заасан хугацааг чанд мөрдөж ажиллахыг “Ард даатгал” ХК-д анхааруулсугай.


4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /М.Өлзийбат/-нд даалгасугай.

ДАРГА

С.ДАВААСҮРЭН



Санхүүгийн зохицуулах хорооны
2019 оны 01 дүгээр сарын 01-ний
өдрийн 01 дүгээр тогтоолын хавсралт



“АРД ДААТГАЛ” ХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ,
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

№	Хувьцаа эзэмшигчийн нэр /Регистрийн дугаар/	Эхний үлдэгдэл			Өөрчлөлт			Эцсийн үлдэгдэл		
		Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 200 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь	Хувьцааны тоо ширхэг	Нэмэгдсэн	Хорогдсон	Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 200 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь
1	“Ард санхүүгийн нэгдэл” ХК	16,679,250	3,335,850,000.00	95.31	75,341	15,068,200.00	-	16,754,591	3,350,918,200.00	67.02%
2	“Энержи интернэйшл капитал” ХХК	820,750	164,150,000.00	4.69	-	-	-	820,750	164,150,000.00	3.28%
3	Бусад*	-	-	-	7,424,659	1,484,931,800.00	-	7,424,659	1,484,931,800.00	29.70%
	Нийт	17,500,000	3,500,000,000.00	100	7,500,000	1,500,000,000.00	-	25,000,000	5,000,000,000	100%